

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ 2020 ОНЫ I УЛИРЛЫН
БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ
ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2020.03.24

Алтай хот

Тус газарт I улирлын байдлаар байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт 6, бусад асуудлаар 3, ажил хүссэн өргөдөл 2, ус ашиглах дүгнэлт гаргуулах, худаг гаргуулах зөвшөөрөл хүссэн хүсэлт 2, Зэрэг дэв шинээр авах, ахиулах, цалингийн шатлал ахиулах, удаан жилийн нэмэгдэл авах өргөдөл 1, чөлөө хүссэн өргөдөл 1, нийт 15 өргөдөл, санал хүсэлт ирснээс 14 өргөдөл, хүсэлтийн хариуг тухай бүрт нь шийдвэрлэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зохих хариуг хуулийн хугацаанд амаар болон албан бичгээр хүргүүлж ажиллалаа. Мөн 1 өргөдлийн иргэнээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдол шийдвэрлэх хуулийн хугацаа болоогүй байна. Үүнд:

1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт 2 иргэн, 4 аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, түүнийг хэрэгжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний батлагдсан аргачлалд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг ажлын 3-7 хоногийн хугацаанд хийн дүгнэлтийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад тус тус хүргүүллээ.

2.Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эм зүйн сургуулийн багш Б.Даваадулам нь нь эрдэм шинжилгээний зориулалтаар 6 төрлийн ургамлын дээж авах, судалгаа, шинжилгээ хийх хүсэлт өмнө нь гаргаж байсан бөгөөд энэ тухай Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-д тодорхойлолт авах хүсэлт ирүүлснийг хүлээн авч албан бичгээр хариуг хүргүүлэв.

Хөхморьт сумын иргэн Ц.Төмөрт байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчилан зохион байгуулах үйл хэрэгт өндөр үр бүтээлтэй ажиллаж буй бөгөөд “Байгаль орчны тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнуулах хүсэлт ирүүлснийг тус газраас БОАЖЯ-д холбогдох баримт бичгийн хамт албан бичгээр хүсэлтийг хүргүүлэн ажиллалаа.

Б.Ганширнэн нь тус газрын архив, бичиг хэргийн эрхлэгчээр 6 жил гаруй хугацаанд ажиллаж буй бөгөөд хууль журамд заасны дагуу Төрийн үйлчилгээний албан хаагчийн ур чадварын нэмэгдэл авах хүсэлт ирүүлснийг хүлээн авч газрын

даргын тушаалаар 2020 оноос эхлэн 10 хувиар тооцон олгохоор шийдвэрлэв.

3.Дарив сумын иргэн О.Ганбаатар нь тус газрын Дарив сум хариуцсан байгаль хамгаалагчийн сул орон тоонд ажиллах хүсэлт ирүүлснийг хүлээн авч Төрийн албан хаагчийн шалгалтад орж тэнцэх хүртэл газрын даргын тушаалаар түр томилон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан ажиллуулж байна.

Мөн Есөнбулаг сумын иргэн Б.Цэнд байгаль орчны чиглэлээр их сургууль төгссөн бөгөөд тус салбарт ажиллах хүсэлтэй байгаа тухай өргөдөл ирүүлснийг одоогоор тус газарт сул ажлын байр байхгүй байгаа, Төрийн албан хаагчийн шалгалтад орохыг зөвлөн хариуг амаар хүргүүллээ.

4.Энэ улиралд 2 аж ахуйн нэгж байгууллагаас ус ашиглах дүгнэлт гаргуулах, худаг гаргуулах зөвшөөрөл хүссэн хүсэлт ирж Монгол Улсын “Усны тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийг үндэслэн 2020 онд худаг гаргуулах, ус ашиглуулах зөвшөөрөл олгон хариуг хуулийн хугацаанд тус тус албажуулан хүргүүллээ.

5.Тус газрын Дэлгэр сум хариуцсан байгаль хамгаалагч Л.Эрдэнэтуяа нь зэрэг дэв шинээр авах, удаан жил ажилласны нэмэгдэл, цалингийн шатлал ахиулах тухай өргөдөл ирүүлснийг хүлээн авч холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн хариуг амаар хүргүүлэв.

6.Тус газрын харуул Б.Хатанбаатарын эхнэрийн баруун хөл хүнд түлэгдэн аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх болсон зэрэг ар гэрийн шалтгаанаар 10 хоногийн цалинтай чөлөө хүссэн өргөдөл ирүүлсэн бөгөөд газрын даргын тушаалаар цалинтай чөлөө олгон шийдвэрлэв.

ХЯНАСАН:

ДАРГА

Д.БАТМАГНАЙ

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
АЖИЛТАН

Б.ГАНШИРНЭН

Тус газрын Баян-Уул сум хариуцсан байгаль хамгаалагч Т.Ганбаатар, Хөхморьт сум хариуцсан байгаль хамгаалагч Б.Жамц, Есөнбулаг сум хариуцсан байгаль хамгаалагч Э.Няндагсүрэн нар зэрэг дэв ахиулах өргөдөл ирүүлснийг хүлээн авч Төрийн албаны тухай хуулийн зэрэг дэв шинээр олгох, ахиулах журам, буюу 2018 оны үр дүнгийн гэрээгээ “А, В” дүгнүүлээгүй зэрэг шаардлага хангахгүй байгаа нь Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөлд зэрэг дэв авах хүсэлтийг уламжлах боломжгүй талаарх хариуг 2019 оны 01 дүгээр сарын 23-нд амаар мэдэгдлээ. Тонхил сум хариуцсан байгаль хамгаалагч Н.Ганболд нь удаан жил ажилласны нэмэгдэл олгуулах өргөдөл гаргасныг хүлээн авч Төрийн албаны хуулинд төрийн албанд 11 жилээс дээш ажилласан албан хаагчдад удаан жил ажилласны 10 хувийн нэмэгдэл олгодог журмын дагуу нэмэгдэл олгогдож байгаа талаар хариуг 2019 оны 01 дүгээр сарын 23-нд амаар мэдэгдлээ.

Мөн Бигэр сум хариуцсан байгаль хамгаалагч М.Гансүх, тус газрын мэргэжилтэн Д.Мөнгөнчимэг, Б.Содмаа, Б.Пүрэвдорж, М.Наранцацрал, Б.Золжаргал, Б.Жавзмаа нар удаан жил ажилласны нэмэгдэл, цалингийн шатлал ахиулах, зэрэг дэв шинээр олгуулах, ахиулах хүсэлтэй өргөдөл ирүүлснийг хүлээн авч Төрийн албаны хуулийн дагуу удаан жилийн нэмэгдэл 5%, 10% олгож байгаа, цалингийн шатлал ахиулсан талаар, Зэрэг дэв шинээр олгох, ахиулах журмын дагуу 2018 оны үр дүнгий гэрээг “А, В” дүгнүүлсэн албан хаагчийн зэрэг дэв авах хүсэлтийг Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөлд тус

газрын 2019 оны 01 дүгээр сарын 22-ны №35 албан бичгээр уламжилсан тухай 2019 оны 01 дүгээр сарын 23-нд амаар хариу мэдэгдлээ.

2. Төгрөг сумын төвд баригдах ерөнхий боловсролын сургуулийн 100 хүүхдийн дотуур байрны барилгын, Халиун сумын төвд эмнэлгийн урд талд шинээр баригдах Эрүүл мэндийн төвийн барилгын, Бигэр сумын иргэн Ц.Энхтөрийн Бигэр сумын төвд Мянгайн хороололд байрлалтай Шатахуун түгээх станцын барилгын, Цогт сумын иргэн Б.Оточхонбаярын Цогт сумын төвд байрлалтай худалдаа үйлчилгээний зориулалт бүхий барилгын төслийн баримт бичигүүдэд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт ирснийг хүлээн авч 2019.01.21-ний №29 албан бичгээр №2019/03, 2019.02.01-ний №47 албан бичгээр №2019/04, 2019.03.15-ны №74 албан бичгээр №2019/05, 2019.03.15-ны №75 албан бичгээр №2019/06 дүгнэлтүүдийг гарган тус тус иргэн аж ахуйн, нэгж байгууллагуудад хүргүүлээ.

3. Алтай сумын иргэн Г.Цэрэн, Д.Доржсүрэн, Б.Мөнх-Эрдэнэ нар тус сум хариуцсан байгаль хамгаалагчаар ажилд орох хүсэлтэй байгаа талаар өргөдөл ирүүлснийг хүлээн авч төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэжлийн шалгалтад орох зөвлөмж өгч хариуг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр болон 03 дугаар сарын 22-ны өдөр амаар мэдэгдлээ.

4. Есөнбулаг сумын Индэрт багийн иргэн Ж. Бат-Эрдэнэ хашаандаа ахуйн хэрэгцээний худаг гаргуулах зөвшөөрөл олгох хүсэлт ирүүлснийг хүлээн авч тус газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/06 дугаар тушаалаар худаг гаргуулах зөвшөөрөл олгов.

Алтай сумын нутагт XV-013593 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эф Ви Эс Пи” ХХК нь ус ашиглуулах хүсэлт ирүүлснийг хүлээн авч тус газрын 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн №79 албан бичгээр 2019 онд ус ашиглах зөвшөөрлийг хүргүүлэв.

5. Тус газрын Жаргалан сум хариуцсан байгаль хамгаалагч М.Одсэр нь Улаанбаатар хот явж баруун мөрний зураг авахуулах зайлшгүй шаардлага гарсан тул 5 хоногийн цалинтай чөлөө хүссэн өргөдөл ирүүлснийг хүлээн авч газрын даргын 2019 оны 01 дүгээр 07-ны өдрийн дугаар Б/03 тушаалаар 5 хоногийн цалинтай чөлөө олгов.

Мөн тус газрын мэргэжилтэн Д.Мөнгөнчимэг нь Улаанбаатар хотод нөхөр хүүхдийнхээ биеийг үзүүлэх, нарийн шинжилгээнд хамруулах зайлшгүй шаардлага гарч ажлын 7 хоногийн цалинтай чөлөө хүссэн өргөдөл ирүүлснийг хүлээн авч

газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн дугаар Б/08 тушаалаар 7 хоногийн цалинтай чөлөө олгов.

6. Тус газрын орчны бохирдол, химийн бодис хариуцсан мэргэжилтэн Б.Золжаргалын хүүхэд харах чөлөөнд түр ажиллаж байсан Э.Цэцэгмаа нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдөл гаргасныг хүлээн авч тус газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дугаар Б/12 тушаалаар үүрэгт ажлаас чөлөөлөв.

7. Тус газрын Чандмань сум хариуцсан байгаль хамгаалагчаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэртээ гарсан Чандмань сумын иргэн Я.Дандар нь Байгаль орчин, аялал жуулчлалын тэргүүн цол тэмдэгээр шагнуулах хүсэлтэй байгаа өргөдөл ирүүлснийг хүлээн авч тус газраас шагналын тодорхойлолтыг БОАЖЯ-д хүргүүлэх шийдвэр гарсан тухай хариуг 2019 оны 03 дугаар сарын 02-нд амаар хүргүүлэв.

ХЯНАСАН:

ДАРГА

Д.БАТМАГНАЙ

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
АЖИЛТАН

Б.ГАНШИРНЭН

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ 2019 ОНЫ II УЛИРЛЫН
БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ
ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2019.06.24

Алтай хот

Тус газарт II улирлын байдлаар ус ашиглуулах хүсэлт, худаг гаргуулах зөвшөөрөл хүссэн хүсэлт 11, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт 5, чөлөө хүссэн өргөдөл 5, ажил хүссэн өргөдөл 2, бусад асуудлаар 1 нийт 24 өргөдөл, санал хүсэлт ирснээс тухай бүрт нь шийдвэрлэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зохих хариуг хуулийн хугацаанд амаар болон албан бичгээр хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Есөнбулаг, Бигэр сумын нутагт орших XV-015337 дугаар хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Марко поло” ХХК-ий худаг гаргах зөвшөөрөл хүссэн хүсэлтийг газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/08 дугаар тушаал, Эрдэнэ сумын нутагт орших XV-017841 тоот хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “ТДЛБЧ” ХХК-ий худаг гаргах зөвшөөрлийн хүсэлтийг 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/12 дугаар тушаалаар тус тус худаг гаргах зөвшөөрөл олгов. “Болд гянт болд” ХХК-ий худаг гаргах зөвшөөрлийн хүсэлтийг Хяргас нуур-Завхан голын захиргааны 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн №019-029 албан бичгийг үндэслэн зөвшөөрөл олгов.

Эрдэнэ сумын ЗДТГ-аас “ТДЛБЧ” ХХК-иар унд ахуйн зориулалтаар худаг гаргуулах зөвшөөрөл хүссэн хүсэлт ирүүлсэн бөгөөд энэхүү ХХК нь тус сумд худаг гаргах боломжгүй гэсэн хариу өгсөн учир өргөдлөө буцаав.

Бигэр сумын нутаг дахь “Агуйт” нэртэй XV-017795 тоот хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Металл эрэл хайгуул” ХХК нь 2019 онд ус ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлснийг газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн №113, Бугат сумын нутагт зам барилгын ажлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Өндөр Алтайн зам” ХХК-ий 2019 онд ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлтийг 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн №118, Бигэр, Есөнбулаг сумдын нутагт XV-00015337, MV-00021243 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Марко поло” ХХК-ий 2019 онд ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлтийг 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн №116, №117, Төгрөг, Бугат сумдын нутагт XV-016656, XV-019034 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Аксис прожект” ХХК-ий 2019 онд ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлтийг 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн №141, Эрдэнэ сумын нутагт XV-017841 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “ТДЛБЧ” ХХК-ий 2019 онд ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлтийг 2019 оны 05 дугаар сарын 13-ны №142, Эрдэнэ сумын нутагт XV-08751 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Нэгүүн дриллинг” ХХК-ий 2019 онд ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлтийг 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн №188, Чандмань сумын нутаг дахь MV-00011956 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Зээгтийн нүүрсний ил уурайн 2019

онд ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлтийг 2019 оны 06 дугаар сарын 20-ны №193 албан бичгээр дүгнэлтийг тус тус хүргүүлээ.

2. Есөнбулаг сумын Жаргалант багт Шүтээний өндөрлөгийн хажуу талд байрлалтай М-ойл групп ХХК-ий Шатахуун түгээх станцын төслийн баримт бичигт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн №2019/08, Иргэн О.Сандуйбаатарын Есөнбулаг сумын Түлшний захад худалдаа үйлчилгээний зориулалтаар барьж буй 4 давхар барилгын төслийн баримт бичигт байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн №2019/09, Шарга сумын шинээр баригдах Эрүүл мэндийн төв, Тонхил сумын “Хөх ам булаг” ХХК-ий ШТС-ийн барилгын төслийн баримт бичигүүдэд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн №2019/10, 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн №2019/10, аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа Хаан банкны салбарын барилга болон түүний өргөтгөлийн барилгын төслийн баримт бичигт байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн №2019/12 дүгнэлтүүдийг тус тус хүргүүлэв.

3. Тус газрын Гуулин тосгон хариуцсан байгаль хамгаалагч Л.Отгон-Эрдэнэ нь Улаанбаатар хотод биеэ үзүүлж нарийн шинжилгээ, оношилгоонд яаралтай хамрагдах шаардлагатай байгаа тул 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс ажлын 10 хоногийн цалинтай чөлөө хүссэн өргөдөл ирүүлснийг хүлээн авч газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б/13 дугаар тушаалаар 10 хоногийн цалинтай чөлөө олгов.

Мөн тус газрын аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байгаад жирэмсэн амаржисаны чөлөө авсан Б.Жавзмаа нь 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл хүүхэд харах чөлөө хүссэн өргөдөл ирүүлж газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар хуулийн дагуу чөлөөг олгов.

БОАЖГ-ын Есөнбулаг сум хариуцсан байгаль хамгаалагч Э.Няндагсүрэн нь 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Улаанбаатар хотод яаралтай бөөрний онош тодруулах шинжилгээнд явах шаардлагатай байгаа тул 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс ажлын 10 хоногийн цалинтай чөлөө, 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Улаанбаатар хотод зүүн талын бөөрний чулууг хайлуулах гуурсыг 2019 оны 05 дугаар сард дурангаар тавиулсан бөгөөд Улаанбаатар хотод гуурсаа яаралтай авахуулах, дахин бөөрний чулуужилтийг нарийн үзүүлж шинжилгээнд орох шаардлагатай байгаа тул 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс ажлын 10 хоногийн цалинтай чөлөө хүссэн өргөдөл тус тус ирүүлснийг хүлээн авч газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 01-ний Б/17, 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн Б/24 дүгээр тушаалаар чөлөө олгов.

Тус газрын архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Ганширнэн нь Улаанбаатар хотод биеэ үзүүлж шинжилгээнд яаралтай хамрагдах шаардлагатай байгаа тул 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс ажлын 5 хоногийн цалинтай чөлөө хүссэн өргөдөл ирүүлснийг газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар шийдвэрлэв.

4. Алтай сумын иргэн Б.Баярсайхан нь тус сум хариуцсан байгаль хамгаалагчаар орох хүсэлтэй өргөдөл 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдөр ирүүлснийг хүлээн авч газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн

дугаар Б/14 тушаалаар Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалтад орж тэнцэх хүртэл дээрх албан тушаалд түр томилов.

Мөн Алтай сумын иргэн Г.Хосбаяр нь тус сумын байгаль хамгаалагчаар ажилд орох өргөдөл 2019 оны 04 дүгээр сарын 03-нд ирүүлснийг хүлээн авч 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр ажлын байр нээлттэй байгаа болон Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалтад орж тэнцэхийг зөвлөн хариуг амаар мэдэгдэв.

5. Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын харъяат Улаанбаатар хотын иргэн зохиолч Я.Дашжамц нь тус аймгийн ховор ургамлын судалгаа хийсэн бөгөөд ном болгон хэвлүүлж гаргахад шаардлагатай байгаа 3.5 сая төгрөгийн санхүүжилт хүссэн өргөдөл (www.eoffice.gov-altai.gov.mn) программаар ирүүлснийг хүлээн авч хариуг газрын 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн дугаар 158 албан бичгээр аймгийн хэмжээнд 2014-2015 оны хооронд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 18 сумын хэмжээнд тархан ургаж байгаа нэн ховор, ховор, ашигт ургамлын судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж гарын авлага, ном товхимол хэвлүүлэн холбогдох газруудад хүргүүлэн ашиглаж буй бөгөөд энэ онд дээрх зардлыг шийдвэрлэх боломжгүй байгаа талаар хариу мэдэгдлээ.

ХЯНАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ОЛОНБААТАР

МЭДЭЭ БИЧСЭН:

БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

Б.ГАНШИРНЭН

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ 2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ
ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2019.06.24

Алтай хот

Тус газарт хагас жилийн байдлаар ус ашиглуулах дүгнэлт гаргуулах, худаг гаргуулах зөвшөөрөлийн хүсэлт 14, зэрэг дэв шинээр авах, ахиулах, цалингийн шатлал ахиулах, удаан жилийн нэмэгдэл авах тухай өргөдөл 11, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт 10, чөлөө хүссэн өргөдөл 7, ажилд орохыг хүссэн өргөдөл 6, бусад асуудлаар 2, ажлаас чөлөөлөгдөх өргөдөл 1 нийт 51 өргөдөл, хүсэлт ирснээс тухай бүрт нь шийдвэрлэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хариуг зохих хуулийн дагуу хугацаанд нь амаар болон албан бичгээр хүргүүлж ажиллалаа. Үүнд:

Хагас жилийн байдлаар худаг гаргуулах зөвшөөрөл 1 иргэн, 5 аж ахуйн нэгж байгууллага, ус ашиглуулах хүсэлт 8 аж ахуйн нэгж, байгууллагаас ирж Монгол Улсын “Усны тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийг үндэслэн 2019 онд худаг гаргуулах, ус ашиглуулах зөвшөөрөл олгон хариуг хуулийн хугацаанд тус тус хүргүүллээ.

Тус газрын 6 мэргэжилтэн, сумд хариуцсан 5 байгаль хамгаалагчаас зэрэг дэв шинээр авах, ахиулах, цалингийн шатлал ахиулах, удаан жилийн нэмэгдэл авах тухай өргөдөл ирүүлж зохих хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэж хариу амаар болон бичгээр мэдэгдлээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт 4 иргэн, 6 аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, түүнийг хэрэгжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний батлагдсан аргачлалд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг ажлын 3-7 хоногийн хугацаанд хийн дүгнэлтийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад тус тус хүргүүллээ.

Тус байгууллагын 7 албан хаагчаас Улаанбаатар хотод биеэ үзүүлэх, нарийн шинжилгээ, оношилгоонд хамрагдах хүсэлтэй 5-10 хоногийн цалинтай чөлөө хүссэн өргөдөл ирүүлж Хөдөлмөрийн хууль болоод зохих хууль, журмын дагуу газрын даргын тушаалаар чөлөө олгон шийдвэрлэлээ.

Тус газрын Алтай сум хариуцсан байгаль хамгаалагчийн сул орон тоонд ажиллах хүсэлтэй өргөдөл 6 иргэн ирүүлж газрын даргын тушаалаар 1 иргэнийг

Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалтад орж тэнцэх хүртэл түр томилон бусад 5 иргэнд Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалтад орохыг зөвлөн хариуг амаар мэдэгдэв.

Чандмань сум хариуцсан байгаль хамгаалагчаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэртээ гарсан Чандмань сумын иргэн Я.Дандар нь Байгаль орчин, аялал жуулчлалын тэргүүн цол тэмдэгээр шагнуулах хүсэлтэй байгаа өргөдөл ирүүлснийг хүлээн авч тус газраас шагналын тодорхойлолтыг БОАЖЯ-д хүргүүлэх шийдвэр гарсан тухай хариуг амаар, Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын харъяат Улаанбаатар хотын иргэн зохиолч Я.Дашжамц нь аймгийн ховор ургамлын судалгаа хийсэн бөгөөд ном болгон хэвлүүлж гаргахад шаардлагатай байгаа 3.5 сая төгрөгийн санхүүжилт хүссэн өргөдөл (www.eofficce.gov-altai.gov.mn) программаар ирүүлснийг хүлээн авч энэ онд дээрх зардлыг шийдвэрлэх боломжгүй байгаа талаар албан бичгээр тус тус хариу мэдэгдлээ.

Тус газрын орчны бохирдол, химийн бодис, байгалийн гамшиг хариуцсан мэргэжилтэн Б.Золжаргалын хүүхэд харах чөлөөнд түр ажиллаж байсан Э.Цэцэгмаа нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдөл гаргасныг хүлээн авч тус газрын даргын тушаалаар үүрэгт ажлаас чөлөөлөв.

ХЯНАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ОЛОНБААТАР

МЭДЭЭ БИЧСЭН:

БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

Б.ГАНШИРНЭН

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ 2019 ОНЫ III УЛИРЛЫН
БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ
ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2019.09.25

Алтай хот

Тус газарт III улирлын байдлаар тодорхойлолт хүсэх тухай 11, ус ашиглуулах хүсэлт, худаг гаргуулах зөвшөөрлийн хүсэлт 7, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт 5, ажилдаа эргэн орох, ажил хүссэн өргөдөл 2, чөлөө хүссэн өргөдөл 1 нийт 26 өргөдөл, санал хүсэлт ирснээс 25 өргөдөл, хүсэлтийг тухай бүрт нь шийдвэрлэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зохих хариуг хуулийн хугацаанд амаар болон албан бичгээр хүргүүлж ажиллалаа. Худаг гаруулах зөвшөөрлийн 1 хүсэлтийн өргөдөл гомдол шийдвэрлэх хуулийн хугацаа болоогүй. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуйн газраас жижиг дунд үйлвэрлэлийг дэмжих зорилгоор зарласан төсөлд шалгарсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас эрхлэх гэж буй үйлдвэрлэл нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй болохыг тодорхойлсон албан бичиг хүссэн бөгөөд тодорхойлолтыг 1-2 хоногийн дотор гаргаж үйлчиллээ.

Тус улирлын байдлаар худаг гаргуулах зөвшөөрөл, ус ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлт 7 аж ахуйн нэгж, байгууллагаас ирж Монгол Улсын “Усны тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу 2019 онд худаг гаргуулах, ус ашиглуулах зөвшөөрөл олгон 6 аж ахуйн нэгж, байгууллагад хариуг хуулийн хугацаанд тус тус хүргүүллээ. Борлуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг Тотал дистрибьюшн ХХК нь тус аймагт хүнсний бүтээгдэхүүн хадгалах агуулахын барилга барих гэж байгаатай холбогдуулан худаг гаргах зөвшөөрөл хүссэн бөгөөд өргөдөл, гомдол шийдвэрлэх хуулийн хугацаа болоогүй байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт 5 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, түүнийг хэрэгжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний батлагдсан аргачлалд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт болон холбогдох хариуг ажлын 3-7 хоногийн хугацаанд иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад тус тус хүргүүллээ.

Тус газрын ахлах мэргэжилтэн Я.Жаргалцэцэг хүүхэд харах чөлөө дуусч ажилдаа эргэн орох өргөдөл ирүүлсэн бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4, 36 дугаар зүйлийн 36.1.3 дахь заалтад заасны дагуу газрын даргын тушаалаар ажилд нь эргүүлэн томилов.

Мөн Есөнбулаг сумын Харзат багийн иргэн Б.Ганзориг тус газарт харуулын ажилд орох өргөдөл ирүүлснийг хүлээн авч Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу газрын даргын тушаалаар харуул хамгаалалтын ажилтнаар түр томилов.

Тус газрын харуул хамгаалалтын ажилтан Г.Мөнгөнхуяг нь ар гэрийн шалтгаанаар 6 сарын цалингүй чөлөө хүссэн өргөдөл ирүүлснийг хүлээн авч Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу газрын даргын тушаалаар чөлөө олгон шийдвэрлэлээ.

ХЯНАСАН:

ДАРГА

Д.БАТМАГНАЙ

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
АЖИЛТАН

Б.ГАНШИРНЭН

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ 2019 ОНЫ IV УЛИРЛЫН
БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ
ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2019.12.25

Алтай хот

Тус газарт IV улирлын байдлаар ус ашиглуулах хүсэлт, зөвшөөрөл худаг гаргуулах зөвшөөрлийн хүсэлт 8, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт 5, ажилдаа эргэн орох, ажил хүссэн өргөдөл 6, бусад асуудлаар 4, тодорхойлолт хүсэх тухай 1 нийт 24 өргөдөл, санал хүсэлт ирсэн бөгөөд тухай бүрт нь шийдвэрлэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчдад зохих хариуг хуулийн хугацаанд амаар болон албан бичгээр хүргүүлж ажиллалаа. Үүнд:

Аймгийн хэмжээнд ус ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас худаг гаргуулах зөвшөөрөл, ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл гаргуулах 8 хүсэлт ирж Монгол Улсын “Усны тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу 2019 онд худаг гаргуулах зөвшөөрөл, ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл олгон хариуг хуулийн хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт 5 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, түүнийг хэрэгжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний батлагдсан аргачлалд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт болон холбогдох хариуг ажлын 3-7 хоногийн хугацаанд иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлээ.

Тус газрын Дарив сум хариуцсан байгаль хамгаалагчийн сул орон тоонд ажиллах хүсэлт ирүүлсэн иргэн Т.Ганхүү, Б.Хүрэлболд нарт Төрийн жинхэнэ албан

хаагчийн шалгалтад орж нөөцөд бүртгүүлэх талаар зөвлөж хариуг амаар хүргүүлэв.

Есөнбулаг сумын иргэн Д.Отгонбаяр, Ж.Гантөмөр нар тус газарт харуул хамгаалалтын ажилд орох хүсэлт ирүүлсэн бөгөөд одоогоор сул орон тоо байхгүй талаар хариуг амаар мэдэгдэв.

Тус газрын аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Жавзмаа нь хүүхэд харах чөлөө, харуул Г.Мөнгөнхуяг нь 6 сарын чөлөөний хугацаа дуусч ажилдаа эргэн орох хүсэлт тус тус гаргасан бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4, 36 дугаар зүйлийн 36.1.3 дахь заалтад заасны дагуу 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс ажилд нь эргэн оруулахаар шийдвэрлэв.

Тус газрын Баян-Уул, Цогт сумд хариуцсан байгаль хамгаалагч Т.Ганбаатар, А.Алтайбаатар нар нь зэрэг дэв шинээр авах, цалингийн шатлал ахиулах, удаан жилийн нэмэгдэл авах тухай өргөдөл ирүүлж зохих хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэж хариу амаар мэдэгдлээ.

Мөн Есөнбулаг сум хариуцсан байгаль хамгаалагч Э.Энхбаатар нь албан үүргээ гүйцэтгэж байх явцад нь мотоцикль нь эвдэрч сэлбэг худалдаж авсан бөгөөд төлбөрийг шилжүүлж өгөх өргөдөл ирүүлснийг хүлээн авч байгууллагын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн зардлаас холбогдох мөнгийг Япон авто сэлбэгийн дэлгүүрт шилжүүлж шийдвэрлэв.

Байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Ганширнэн нь архивын зэргийн нэмэгдэл авах тухай өргөдөл ирүүлсэн бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2005 оны 15/41/25 дугаар тушаалаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтанд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам”-ын дагуу газрын даргын тушаалаар архивын зэргийн нэмэгдэл 10 хувийг олгохоор шийдвэрлэв.

Хүнс, хөдөө аж ахуйн газраас жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зарласан төсөлд шалгарсан 1 иргээс эрхлэх гэж буй үйлдвэрлэл нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй болохыг тодорхойлсон албан бичиг хүссэн бөгөөд тодорхойлолтыг 1-2 хоногийн дотор гаргаж үйлчиллээ.

ХЯНАСАН:

ДАРГА

Д.БАТМАГНАЙ

МЭДЭЭ ГАРГАСАН:

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ 2019 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ
ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2019.12.25

Алтай хот

Тус газарт жилийн эцсийн байдлаар ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, худаг гаргуулах зөвшөөрөлийн хүсэлт 29, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт 20, ажилдаа эргэн орох, ажил хүсэх тухай 14, зэрэг дэв шинээр авах, ахиулах, цалингийн шатлал ахиулах, удаан жилийн нэмэгдэл авах тухай өргөдөл 13, тодорхойлолт хүсэх тухай 12, чөлөө хүссэн өргөдөл 8, бусад асуудлаар 4, ажлаас чөлөөлөгдөх өргөдөл 1 нийт 101 өргөдөл, хүсэлт ирснээс тухай бүрт нь шийдвэрлэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчдад хариуг зохих хуулийн дагуу хугацаанд нь амаар болон албан бичгээр хүргүүлж ажиллалаа. Үүнд:

Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд ус ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас худаг гаргуулах зөвшөөрөл, ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл гаргуулах 29 хүсэлт ирж Монгол Улсын “Усны тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу 2019 онд худаг гаргуулах зөвшөөрөл, ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл олгон хариуг хуулийн хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүллээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт 20 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, түүнийг хэрэгжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний батлагдсан аргачлалд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт болон холбогдох хариуг ажлын 3-7 хоногийн хугацаанд иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлээ.

Тус газрын Алтай, Дарив сумд хариуцсан байгаль хамгаалагчийн сул орон тоонд ажиллах хүсэлт гаргасан 8 иргэнээс Алтай сумын байгаль хамгаалагчаар газрын даргын тушаалаар 1 иргэнийг Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалтад орж тэнцэх хүртэл түр томилон бусад иргэдэд Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалтад орж тэнцэн нөөцөд бүртгүүлэхийг зөвлөн хариуг амаар мэдэгдэв.

Байгууллагын харуул хамгаалалтын ажилтнаар орох хүсэлт 3 иргэнээс ирж газрын даргын тушаалаар 1 иргэнийг тус газрын харуулаар түр томилон бусад 2 иргэнд дахин сул орон тоо байхгүй талаар хариуг амаар мэдэгдлээ.

Тус газрын 2 мэргэжилтэн хүүхэд харах чөлөө, 1 харуул 6 сарын чөлөөний хугацаа дуусч ажилдаа эргэн орох хүсэлт гаргасан бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4, 36 дугаар зүйлийн 36.1.3 дахь заалтад заасны дагуу газрын даргын тушаалаар 1 албан хаагчийг ажилд нь эргүүлэн оруулж, 2 албан хаагчийг 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс оруулахаар шийдвэрлэв.

Тус газрын 6 мэргэжилтэн, сумд хариуцсан 7 байгаль хамгаалагчаас зэрэг дэв шинээр авах, ахиулах, цалингийн шатлал ахиулах, удаан жилийн нэмэгдэл авах тухай өргөдөл ирүүлж зохих хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэж хариуг амаар болон бичгээр мэдэгдлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн газраас жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зарласан төсөлд шалгарсан 12 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас эрхлэх гэж буй үйлдвэрлэл нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй болохыг тодорхойлсон албан бичиг хүссэн бөгөөд тодорхойлолтыг 1-2 хоногийн дотор гаргаж үйлчиллээ.

Чандмань сум хариуцсан байгаль хамгаалагчаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэртээ гарсан Чандмань сумын иргэн Я.Дандар нь Байгаль орчин, аялал жуулчлалын тэргүүн цол тэмдэгээр шагнуулах хүсэлтэй байгаа өргөдөл ирүүлснийг хүлээн авч тус газраас шагналын тодорхойлолтыг БОАЖЯ-д хүргүүлэх шийдвэр гарсан тухай хариуг амаар, Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын харъяат Улаанбаатар хотын иргэн зохиолч Я.Дашжамц нь аймгийн ховор

ургамлын судалгаа хийсэн бөгөөд ном болгон хэвлүүлж гаргахад шаардлагатай байгаа 3.5 сая төгрөгийн санхүүжилт хүссэн өргөдөл (www.eoffice.gov-altai.gov.mn) программаар ирүүлснийг хүлээн авч энэ онд дээрх зардлыг шийдвэрлэх боломжгүй байгаа талаар албан бичгээр тус тус хариу мэдэгдлээ.

Есөнбулаг сум хариуцсан байгаль хамгаалагч Э.Энхбаатар нь албан үүргээ гүйцэтгэж байх явцад нь мотоцикль нь эвдэрч сэлбэг худалдаж авсан бөгөөд төлбөрийг шилжүүлж өгөх өргөдөл ирүүлснийг хүлээн авч байгууллагын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн зардлаас холбогдох мөнгийг Япон авто сэлбэгийн дэлгүүрт шилжүүлж шийдвэрлэв.

Байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Ганширнэн нь архивын зэргийн нэмэгдэл авах тухай өргөдөл ирүүлсэн бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2005 оны 15/41/25 дугаар тушаалаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтанд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам”-ын дагуу газрын даргын тушаалаар архивын зэргийн нэмэгдэл 10 хувийг олгохоор шийдвэрлэв.

Тус газрын орчны бохирдол, химийн бодис, байгалийн гамшиг хариуцсан мэргэжилтэн Б.Золжаргалын хүүхэд харах чөлөөнд түр ажиллаж байсан Э.Цэцэгмаа нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдөл гаргасныг хүлээн авч тус газрын даргын тушаалаар үүрэгт ажлаас чөлөөлөв.

ХЯНАСАН:

ДАРГА

Д.БАТМАГНАЙ

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН

АЖИЛТАН

Б.ГАНШИРНЭН